

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

2023 оны 2 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн Газар нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах хүрээнд “Дэлхийн Олборлох үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр-2”-т зориулсан Олон талт итгэлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг зохицуулах үүрэг бүхий Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк / Олон Улсын Хөгжлийн Ассоциацаас (цаашид “Банк” гэх) Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын 2022-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг авч байна.

“ОУИТБС-ыг хэрэгжүүлж Олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх” энэхүү төслийн зорилго нь ОУИТБС-ын оролцогч талуудын хамтын ажиллагаа оролцоог бэхжүүлэх, ОУИТБС-ын өгөгдлийг мэдээллийн үндсэн суурь урсгал болгох болон түүнийг ашиглах чадавхыг нэмэгдүүлэхэд оршиж, Монгол Улсын эрдэс баялгийн удирдлагын хариуцлагыг бэхжүүлэх замаар ил тод, системтэй тайлагналын системийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Төслийн өдөр тутмын үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхий Сайдын 2007 оны 62 тоот захирамжаар байгуулагдсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын ажлын алба хариуцах бөгөөд 2019 оноос УУХҮЯ-ны удирдлага дор ажиллаж байна. Тус алба нь 2023 онд тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд дараах мэргэжилтнийг ажиллуулах тул шаардлагад нийцсэн хүмүүсийг сонгон шалгаруулалтад урьж байна.

Албан тушаалын нэр: Мэдээлэл технологийн мэргэжилтэн

Ажлын байрны зорилго: ОУИТБС-ын Цахим тайлагналын системийг ажиллуулах, боловсронгуй болгох, ОУИТБС-ын жил бүрийн тайлан гаргахад дэмжлэг үзүүлнэ.

Ажлын байрны зорилт: ОУИТБС-ын мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг боловсруулж гаргах, хэвийн ажиллагааг хангах, сайжруулах саналыг боловсруулж, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хүлээж авах, ОУИТБС-ын Ажлын албаны цахим хуудсыг тогтмол ажиллуулна.

Ажлын байрны чиг үүрэг: Цахим тайлангийн системийг боловсронгуй болгох талаар судалж, системийн шаардлага боловсруулах, аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, цахим тайлангийн системийг өгөгдлийн сангаас мэдээлэл боловсруулах, Цахим тайлангийн системийн өгөгдлийн сангийн нөөц хувилбарыг журмын дагуу авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, ОУИТБС-ын цахим хуудсыг ажиллуулах, тогтмол шинэчлэхэд хамтран ажиллах, цахим хуудасны өгөгдлийн сангийн нөөц хувилбарыг тогтмол авч, аюулгүй хэвийн ажиллагааг хангах, харилцааны мэргэжилтэнтэй санаачилгын талаар мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр, нийгмийн сүлжээгээр түгээхэд дэмжлэг үзүүлэх, цахим тайлангийн системийн талаар сургалт хийж, зөвлөгөө өгөх, компани болон төрийн байгууллагуудын тайланг хүлээн авах, тулган баталгаажуулалтын явцад хараат бус нэгтгэгчид дэмжлэг үзүүлэх, хариуцсан ажлынхаа худалдан авалтыг зохион байгуулах, холбогдох орчуулгыг хариуцах;

Ажлын байранд тавигдах шаардлага: Програм хангамж, Мэдээллийн технологи, Мэдээллийн чиглэлээр дээд боловсролтой, бакалавр түүнээс дээш зэрэгтэй, Вэб суурьтай програм хангамж боловсруулах чиглэлээр туршлагатай, өгөгдлийн баазтай ажиллаж байсан туршлагатай,

Системийн шинжилгээ хийх, Програм хангамжийн чанарыг шалгах, хүлээж авах, сайжруулах санал боловсруулах чадвартай 2- оос доошгүй жил ажилласан, англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй (IELTS-ийн 5,5-6, TOEFL-ийн 65-75 оноог хангасан байх), төрийн худалдан авалтын АЗ гэрчилгээтэй байвал илүү зохимжтой.

Сонгон шалгаруулалтад оролцох иргэн дээр дурдсан шаардлагуудыг бүрэн хангасан тухай нотлох баримтуудын хамт хүсэлтээ тус албаны eiti.secretariat.mn@gmail.com гэсэн хаягаар 2023 оны 2-р сарын 14-ний өдрийн 21.00 цагаас өмнө цахимаар илгээнэ үү. Хураангуй жагсаалтад орсон иргэнтэй холбоо барьж, ярилцлагад урина. Лавлагааг дээр дурдсан цахим шуудангаар 2023 оны 2-р сарын 14-ний өдрийн 17.00 цагаас өмнө авч дуусгана.

Бүрдүүлэх материал

Намтар (CV), иргэний үнэмлэхийн хуулбар, их, дээд сургуулийн дипломны хуулбар, мэргэшсэн сургалт, хөтөлбөрүүдийн батламжийн хуулбар, ажиллаж байсан, эсхүл байгаа ажлын газрын тодорхойлолт (1-ээс доошгүй).

ОУИТБС-ын Ажлын алба